


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2023 ОНЫ ЭХНИЙ 01 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ)

ГАДААД ХУДАЛДАА (2023 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2023 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 1,765.7 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 61.1 хувь буюу 669.5 сая ам.доллараар өссөн, гадаад худалдааны тэнцэл 389.7 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	01 дүгээр сар				Өөрчлөлт 2023/2022	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	932.3	1,098.7	1,096.1	1,765.7	669.5	61.1
-Экспорт	459.0	639.8	539.6	1,077.7	538.1	99.7
-Импорт	473.3	458.8	556.5	688.0	131.5	23.6
Тэнцэл	-14.3	181.0	-16.9	389.7	406.6	-

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2023 оны эхний 01 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 389.7 сая ам.долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 406.6 сая ам.доллаар өссөн байна.

Экспорт: Экспортод 1,077.7 сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 99.7 хувиар өссөн байна. Экспортод нийлүүлсэн барааны 99.7 хувийг валютын төлбөртэй худалдаа эзэлж байна.

Импорт: Импортоор нийт 688.0 сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2022 оны мөн үеэс 131.5 сая ам.доллараар буюу 23.6 хувиар өссөн байна. Импортоор нийлүүлэгдсэн барааны 96.3 хувийг валютын төлбөртэй худалдаа, 1.1 хувийг гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 0.9 хувийг гадаадын тусламжийн бараа, 2.3 хувийг гадаадын хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, 0.2 хувийг реимпорт эзэлж байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын 81.2 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 18.8 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 875.6 сая ам.доллар болж, өмнөх оноос 533.2 сая

ам.доллар буюу 155.7 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 202.1 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 4.9 сая ам.доллар буюу 2.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	01 дүгээр сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	431.9	562.7	342.4	875.6	533.2	155.7	81.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	27.1	77.2	197.2	202.1	4.9	2.5	18.8
Нийт экспорт	459.0	639.9	539.6	1,077.7	538.1	99.7	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 17.0 хувийг зэсийн баяжмал, 52.5 хувийг нүүрс, 11.3 хувийг боловсруулаагүй алт, 2.9 хувийг цайрын

баяжмал, 0.6 хувийг самнасан ноолуур, бохир ноолуур 0.2 хувийг тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	01 дүгээр сар				Өмнөх оны мөн үеэс	
		2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	101.6	109.6	81.0	110.6	29.7	36.7
Нүүрс	сая.тн	2.4	2.5	0.6	3.5	2.9	466.8
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	8.2	0.6	0.04	0.36	0.3	757.9
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	12.8	11.8	3.3	20.2	16.9	507.7
Алт	тн	0.0	0.0	2.5	2.0	-0.5	-18.8
Боловсруулаагүй нефть	сая.баррель	0.3	0.5	0.0	0.4	0.4	-
Катодын зэс	тн	1.0	9.6	0.2	0.1	-0.1	-49.9
Жоншны баяжмал	мян.тн	47.5	74.3	13.2	54.7	41.4	312.7
Адууны мах	мян.тн	0.0	2.3	0.0	3.8	3.8	-
Өлөн гэдэс	тн	27.1	21.8	1.9	1.5	-0.4	-20.3

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	4.4	0.0	0.1	0.4	0.3	368.1
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.0	22.3	0.0	8.4	8.4	-
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	4.3	0.002	0.0	0.0	0.0	-
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	14.3	10.3	6.6	5.4	-1.2	-18.1
Самнасан ноолуур	тн	11.1	11.3	52.6	6.0	-46.6	-88.5
Бохир ноолуур	тн	6.1	187.0	642.6	47.2	-595.4	-92.6
Хонины самнаагүй ноос	мян.тн	0.5	0.8	0.0	0.0	0.0	-

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	01 дүгээр сар				Өмнөх оны мөн үеэс	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	114.1	194.3	175.7	183.6	7.9	4.5
Нүүрс	203.4	220.7	143.7	565.3	421.7	293.5
Төмрийн хүдэр	55.5	73.1	3.0	25.9	23.0	776.3
Цайрын баяжмал	18.0	17.7	5.8	30.8	25.0	432.0
Алт	0.0	0.0	143.9	121.8	-22.1	-15.3
Боловсруулаагүй нефть	16.9	25.5	0.0	29.5	29.5	-
Катодын зэс	5.7	59.3	1.5	0.6	-0.9	-57.7
Жоншны баяжмал	13.0	15.9	2.7	14.2	11.5	416.8
Адууны мах	0.0	4.7	0.0	11.3	11.3	-
Өлөн гэдэс	0.6	0.5	0.2	0.1	0.0	-27.7
Үхэр, адууны боловсруулсан шир	0.4	0.0	0.05	0.1	0.0	97.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.0	0.04	0.0	0.0	0.0	-
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.1	0.001	1.3	0.0	-1.3	-100.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.6	0.4	0.2	0.1	0.0	-13.5
Самнасан ноолуур	1.2	0.7	6.2	0.7	-5.5	-88.7
Бохир ноолуур	0.2	6.1	29.4	2.6	-26.8	-91.1
Хонины самнаагүй ноос	0.6	0.8	0.0	0.0	0.0	-
Нийт экспортод эзлэх хувь	93.7	96.8	95.2	91.6		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

/ам.доллар/

Барааны нэр	Хэмжих нэгж	01 дүгээр сар		Өөрчлөлт	
		2022	2023	Зөрүү	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	230.5	160.0	-70.5	-30.6%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	2,169.9	1,659.0	-510.9	-23.5%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	70.4	71.9	1.5	2.2%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,743.7	1,526.5	-217.2	-12.5%
Жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	207.5	259.9	52.4	25.2%
Алт	тн/ам.дол	14,153.2	16,013.3	1,860.2	13.1%

Эх сурвалж: Уул уурхайн яам

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 533.2 сая ам.доллар буюу 55.7 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1.Нүүрс: 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 565.3 сая ам.долларын 3,533.5 мян.тн чулуун нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 421.7 сая ам.доллар буюу 3.9 дахин, биет хэмжээгээр 2,910.1 мян.тн буюу 5.7 дахин тус тус өссөн байна.

Чулуун нүүрсний 98.1 хувийг БНХАУ, 1.3 хувийг Сингапур, 0.6 хувийг БНСУ улс руу тус тус экспортолсон байна.

2.Зэсийн баяжмал: 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 183.6 сая ам.долларын 110.6 мян. тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 7.9 сая ам.доллар буюу 4.5 хувиар, биет хэмжээгээр 29.7 мян.тн буюу 36.7 хувиар тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

3.Цайрын баяжмал: 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 30.8 сая ам.долларын 20.2 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 16.9 мян. тн буюу 6.1 дахин, үнийн дүнгээр 25.0 сая ам.доллар буюу 5.3 дахин тус тус өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

4.Алт: 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 121.8 сая ам.долларын 1,996.0 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 22.1 сая ам.доллар буюу 15.3 хувиар, биет хэмжээгээр 461.0 кг буюу 18.8 хувиар тус тус буурсан байна. Алтны 100 хувийг Швейцар руу экспортолсон байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын 26.2 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 73.8 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 5,564.7 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 911.4 сая ам.доллар буюу 19.6 хувиар өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,580.8 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 589.0 сая ам.доллараар буюу 59.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	01 дүгээр сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	136.7	96.2	131.6	180.2	48.6	36.9	26.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	336.6	362.6	424.9	507.8	82.9	19.5	73.8
Нийт импорт	473.3	458.8	556.5	688.0	131.5	23.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс хувь, химийн болон түүнтэй холбоотой бүтээгдэхүүн 26.2 хувь, машин механик тоног үйлдвэрийн бүтээгдэхүүн 5.4 хувь, үндсэн төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн тэдгээрийн сэлбэг 15.2 хувь, автотээвэр, агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 21.0 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 11.3

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2022.01	2023.01	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	14.4	9.6	-4.8	-33.3	1.4
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	17.4	8.7	-8.8	-50.2	1.3
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	6.3	4.9	-1.4	-22.1	0.7
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	60.4	54.6	-5.8	-9.6	7.9
5	Эрдэс бүтээгдэхүүн	131.6	180.2	48.6	36.9	26.2
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	38.4	37.3	-1.1	-2.8	5.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	19.7	28.5	8.8	44.4	4.1
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	0.5	0.7	0.3	56.2	0.1
9	Мод, модон эдлэл	5.6	4.4	-1.2	-21.0	0.6
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	6.7	6.6	-0.1	-0.9	1.0
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	11.4	10.4	-1.0	-8.7	1.5
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2.0	2.5	0.5	23.4	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	11.0	17.8	6.7	60.7	2.6
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1.7	0.2	-1.5	-87.7	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	37.3	47.3	10.0	26.9	6.9
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	100.0	104.5	4.5	4.5	15.2
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	69.7	144.2	74.6	107.0	21.0
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, тэдгээрийн эд анги	11.2	11.0	-0.2	-1.9	1.6
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	11.1	14.3	3.2	28.4	2.1
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.0	0.0	0.0	0.7	0.0
21	ДҮН	0.0	0.2	0.1	0.3	0.0
	ДҮН	556.5	688.0	131.5	23.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 88.6 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2023 оны 1 дүгээр сарын байдлаар 159.6 сая ам.долларын 176.2 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 25.7 мян.тн буюу 17.1 хувиар, үнийн дүнгээр 44.0 сая ам.доллар буюу 38.1 хувиар тус тус өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 92.6 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 19.9 хувийг автобензин, 72.7 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2023 оны 1 дүгээр сард 401.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж 403.7 тэрбум төгрөг төвлөрүүлжээ.

Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022.01	2023.01		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	280.3	401.9	403.7	123.4	144.0	1.8	100.4
Өөрийн орлого	0.4	0.9	8.7	8.3	2,175.0	7.8	966.7
Хураамж	1.0	3.5	8.5	7.5	850.0	5.0	242.9
Татварын дүн	287.9	397.5	386.5	98.6	134.2	-11.0	97.2
Гаалийн албан татвар	72.0	127.8	112.3	40.3	156.0	-15.5	87.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	151.3	231.6	232.7	81.4	153.8	1.1	100.5
Архи, дарсны онцгой албан татвар	1.7	1.9	1.0	-0.7	58.8	-0.9	52.6
Тамхины онцгой албан татвар	11.8	10.4	14.3	2.5	121.2	3.9	137.5
Шар айрагны онцгой албан татвар	0.3	0.4	0.5	0.2	166.7	0.1	125.0
Суудлын автомашины онцгой албан татвар	21.0	15.7	24.1	3.1	114.8	8.4	153.5
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	19.6	7.7	0.4	-19.2	2.0	-7.3	5.2
Автобензин, дизель түлшний албан татвар	1.3	2.0	1.1	-0.2	84.6	-0.9	55.0
Экспортын татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 123.4 тэрбум төгрөгөөр 44.0 хувиар өссөн байна. Үүнээс:

- Гаалийн албан татвар 40.3 тэрбум төгрөг
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар 81.4 тэрбум,
- Тамхины онцгой албан татвар 2.5 тэрбум төгрөг,
- Шар айрагны онцгой албан татвар 0.2 тэрбум төгрөг,
- Суудлын автомашины онцгой албан татвар 3.1 тэрбум төгрөг,
- Өөрийн орлого 8.3 тэрбум төгрөг,
- Хураамжийн орлого 7.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.
- Хураамжийн орлого 11.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин архи, дарсны онцгой албан татвар 0.6 тэрбум төгрөг, автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 19.2 тэрбум төгрөг, автобензин, дизелийн түлшний албан татвар 0.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тус барааны онцгой албан татвараар 2023 оны 1 дүгээр сард 15.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 24.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 153.2 хувийн гүйцэтгэлтэй, өнгөрсөн оны мөн үетэй орлогыг харьцуулахад 3.1 тэрбум төгрөгөөр өсөлттэй гарчээ. Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 4661 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1016 ширхэг буюу 17.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 4 ширхэгээр, бусад суудлын автомашин 1012 ширхэгээр тус тус буурсан.

Хүснэгт 9. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл	Импортын тоо хэмжээ /ширхэг/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
	2022.1	2023.1	зөрүү	хувь	2022.01	2023.01	Зөрүү	Хувь
Хос тэжээлт	4134	4,130	-4	99.9	14.1	14.1	0.0	100
Бусад	1543	531	-1,012	34.4	8.2	5.6	-2.6	68
Нийт	5677	4,661	-1,016	82.1	22.3	19.7	-2.6	88

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлш: Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2022 оны 1 дүгээр сард 150.1 мянган тн, 2023 оны 1 дүгээр сард 144.9 мянган тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

Хүснэгт 10. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл		Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
		2022.01	2023.01	Зөрүү	Хувь	2022.1	2023.1	Зөрүү	Хувь
Нийт		150.08	144.89	4.1	96.5%	24.47	0.37	-24.1	0.0%
Автобензин	A-80	1.29	2.29	1.0	178.3%	-	-	-	-
	A-92	45.41	27.52	-17.9	60.6%	-	-	-	-
	A-95 болон түүнээс дээш	1.83	1.76	-0.1	96.4%	0.4	0.4	0.0	4.2%
Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин		9.28	-	-9.3	100.0%	1.5	-	-1.5	0.0%
Дизель түлш		92.28	113.32	21.0	122.8%	22.60	53.6	-22.6	0.0%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дизель түлшний нэг тонн импортын дундаж үнэ 954.7 ам.долларт хүрч 2022 оны 12 дугаар сартай харьцуулахад 149.8 ам.доллар буюу 13.6 хувиар буурсан бол, 2022 оны 1 дүгээр сартай харьцуулахад 190.18 ам.доллар буюу 24.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тав. Татварын чөлөөлөлт

Татвараас чөлөөлөгдсөн импорт нь 2023 оны 1 дүгээр сард 182.4 тэрбум төгрөгт хүрч, түүнд ногдуулсан **26.7 тэрбум** төгрөгийн татварыг хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. 2023 оны 1 дүгээр сард нийт импортод татвартай импорт 91.2 хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ 8.8

хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 399.5 тэрбум төгрөгөөр буюу 26.8 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт 138.3 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022.01	2023.01	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	1,490.9	1,890.4	399.5	126.8%
<i>Эзлэх хувь</i>	<i>97.1%</i>	<i>91.2%</i>	<i>-5.9%</i>	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	44.04	182.4	138.3	414.1%
<i>Эзлэх хувь</i>	<i>2.9%</i>	<i>8.8%</i>	<i>5.9%</i>	
Нийт импорт	1,534.9	2,072.7	537.8	135.0%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

1. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан тусламжийн хүрээнд 6.1 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий 0.8 тэрбум тэрбум төгрөг,
2. БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016-09-07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-аар Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь 48.1 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд 7.5 тэрбум төгрөг,
3. Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг болох 0.5 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан 0.1 тэрбум төгрөг,
4. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 26.2 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд 3.5 тэрбум төгрөг,
5. ХАА-ын зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис бүхий нийт 13.0 тэрбум төгрөгийг статистик дүн бүхий бараанд ногдуулсан 1.4 тэрбум төгрөг,
6. Бусад татварын хуулийн зүйл заалтуудаар 9.9 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд 1.3 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Хүснэгт 12. Татварын чөлөөлөлт

/тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2022 оны 1 сар		2023 оны 1 сар		өөрчлөлт (2023/2022)	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	1.1	0.1	13.0	1.4	11.9	1.3
2	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	7.8	1.1	6.1	0.8	-1.7	-0.3
3	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ болон газрын тосны компаниудын тоног төхөөрөмж	15.9	4.0	48.1	7.5	32.3	3.5
4	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	0.4	0.1	0.5	0.1	0.1	0.0
5	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	0.7	0.1	21.27	3.30	20.6	3.2
6	Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	6.2	0.8	26.2	3.5	26.2	3.5
7	Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	4.7	0.7	10.8	1.7	6.1	0.9
8	Автобус троллейбус			48.1	7.5		
9	Бусад	7.3	1.0	9.9	1.3	2.6	0.3
	Дүн	44.1	7.9	182.4	26.7	138.3	18.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**